



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

«Нийслэлийн өмчид 5 барилга байгууламж»  
бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, Арабын Нэгдсэн Эмират улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Багануур, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт тус тус шинээр баригдаж ашиглалтад орсон нийт 12,818,194,415 /арван хоёр тэрбум найман зуун арван найман сая нэг зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун арван тав/ төгрөгийн өртөг бүхий хавсралтад дурдсан 5 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100475